



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/11/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ц.Энхжаргал  
Утас: 261740 Цахим хаяг: [enkhjargalts@audit.gov.mn](mailto:enkhjargalts@audit.gov.mn)

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	13
3.5.2 Авлага .....	13
3.5.3 Бараа материал .....	13
3.5.4 Бусад эргэлтийн хөрөнгө .....	14
3.5.5 Үндсэн хөрөнгө .....	14
3.5.6 Өр төлбөр .....	15
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	18
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт .....	20
4.1 Харьяа байгууллагууд.....	20
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	20
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа .....	20
4.2.2 Албан шаардлага .....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	22
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	24
6. Акт, албан шаардлага .....	26

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  
Б.БААСАНДОРЖ ТАНАА

2022.03.25 № 01/716  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,795.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/мянган төгрөгөөр/*

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,711,453.7	7,430,505.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	344,370.3	210,713.8
33	АВЛАГА	72,007.1	167,362.9
34	УРЬДЧИЛГАА	65.0	1,145.0
35	БАРАА МАТЕРИАЛ	6,295,011.3	5,478,283.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	1,573,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,684,496.8	41,457,786.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,684,496.8	41,457,786.8
39200	Биет хөрөнгө	35,785,783.7	39,411,606.6
39300	Биет бус хөрөнгө	1,898,713.1	2,046,180.2
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>44,395,950.5</b>	<b>48,888,292.0</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	296,187.6	198,617.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	296,187.6	198,617.4
41300	Өглөг	296,187.6	198,617.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	44,099,762.9	48,689,674.6
51	Засгийн газрын хувь оролцоо	44,099,762.9	48,689,674.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,447,971.3	16,447,971.3
51200	Хуримтлагдсан үр дүн	24,793,074.1	29,233,605.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,858,717.5	3,008,098.2
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>44,395,950.5</b>	<b>48,888,292.0</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>57,679,559.5</b>	<b>57,763,235.7</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		9,372,093.0	12,115,943.8
120	Нийтлэг татварын бус орлого		9,372,093.0	6,850,499.3
122	Тусламжийн орлого		0.0	5,265,444.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		48,307,466.5	45,647,291.9
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>49,457,190.9</b>	<b>53,361,792.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		49,457,190.9	53,361,792.5
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		43,789,262.1	46,353,122.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		26,997,031.8	27,367,867.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,412,920.7	3,615,013.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,869,670.1	1,872,144.4
2104	Хангамж, бараа материалын зардал		2,544,924.2	2,893,865.0
2105	Нормативт зардал		1,017,789.9	1,133,130.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,293,463.8	1,593,465.6
2107	Томилолт, зочны зардал		614,837.2	618,222.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		823,777.7	1,162,572.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,214,846.7	6,096,840.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,667,928.8	7,008,669.6
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>8,222,368.6</b>	<b>4,401,443.2</b>
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,133,813.0	7,531.4
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>6,088,555.6</b>	<b>4,393,911.8</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/мянган төгрөгөөр/*

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,998,088.5</b>	<b>0.0</b>	<b>37,998,088.5</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	116,651.2	0.0	116,651.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,114,739.7	0.0	38,114,739.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-163,266.4	0.0	-163,266.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	59,734.0	0.0	59,734.0
9	Тайлант үеийн үр дүн	6,088,555.6	0.0	6,088,555.6
10	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>44,099,762.9</b>	<b>0.0</b>	<b>44,099,762.9</b>
11	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>44,099,762.9</b>	<b>0.0</b>	<b>44,099,762.9</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	46,619.3	0.0	46,619.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,146,382.2	0.0	44,146,382.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	149,380.6	0.0	149,380.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	4,393,911.8	0.0	4,393,911.8
20	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>48,689,674.6</b>	<b>0.0</b>	<b>48,689,674.6</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>52,059,171.2</b>	<b>49,423,023.3</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,751,739.7	3,742,689.3
120	Нийтлэг татварын бус орлого		3,751,739.7	3,742,689.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		48,307,431.5	45,680,334.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>48,811,276.1</b>	<b>48,011,076.1</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		48,811,276.1	48,011,076.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		41,900,308.8	40,601,314.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27,009,048.9	27,355,267.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,399,752.0	3,619,390.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,869,679.8	1,974,382.2
2104	Хангамж, бараа материалын зардал		1,784,030.1	1,736,680.1
2105	Нормативт зардал		1,597,143.4	1,213,729.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,903,975.5	1,432,519.7
2107	Томилолт, зочны зардал		618,629.0	623,310.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		903,992.3	1,420,243.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,814,057.8	1,225,790.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,910,967.3	7,409,762.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		<b>3,247,895.1</b>	<b>1,411,947.2</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>3,278,381.1</b>	<b>1,545,603.7</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,278,381.1	1,545,603.7
2200	Дотоод эх үүсвэрээр		3,278,381.1	1,545,603.7
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		<b>-3,278,381.1</b>	<b>-1,545,603.7</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>		<b>-30,486.0</b>	<b>-133,656.5</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		374,856.3	344,370.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		344,370.3	210,713.8



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		344,370,287.00		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>44,435,180,500.00</b>	<b>42,381,398,690.35</b>	<b>2,053,781,809.65</b>	95.4
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>43,047,180,500.00</b>	<b>40,993,398,690.35</b>	<b>2,053,781,809.65</b>	95.2
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>41,488,550,600.00</b>	<b>39,529,339,908.75</b>	<b>1,959,210,691.25</b>	95.3
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>27,739,717,600.00</b>	<b>27,022,177,976.84</b>	<b>717,539,623.16</b>	97.4
Үндсэн цалин	20,422,236,700.00	19,796,359,859.61	625,876,840.39	96.9
Нэмэгдэл	5,943,844,200.00	5,766,444,761.40	177,399,438.60	97.0
Унаа хоолны хөнгөлөлт	1,301,426,000.00	1,398,478,327.42	-97,052,327.42	107.5
Урамшуулал	72,210,700.00	60,895,028.41	11,315,671.59	84.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,744,862,600.00</b>	<b>3,577,168,890.43</b>	<b>167,693,709.57</b>	95.5
Тэтгэврийн даатгал	2,635,273,100.00	2,500,717,834.86	134,555,265.14	94.9
Тэтгэмжийн даатгал	277,397,000.00	273,082,596.29	4,314,403.71	98.4
ҮОМШӨ-ий даатгал	221,918,600.00	217,536,441.10	4,382,158.90	98.0
Ажилгүйдлийн даатгал	55,479,000.00	55,386,542.83	92,457.17	99.8
Эрүүл мэндийн даатгал	554,794,900.00	530,445,475.35	24,349,424.65	95.6
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,159,358,800.00</b>	<b>1,968,425,361.78</b>	<b>190,933,438.22</b>	91.2
Гэрэл, цахилгаан	326,630,400.00	259,645,018.44	66,985,381.56	79.5
Түлш, халаалт	1,029,826,600.00	956,271,754.55	73,554,845.45	92.9
Цэвэр, бохир ус	171,080,700.00	136,971,894.79	34,108,805.21	80.1
Байрны түрээс	631,821,100.00	615,536,694.00	16,284,406.00	97.4
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,756,638,200.00</b>	<b>1,627,720,671.69</b>	<b>128,917,528.31</b>	92.7
Бичиг хэрэг	405,717,200.00	373,860,502.00	31,856,698.00	92.1
Тээвэр, шатахуун	790,366,600.00	746,399,863.00	43,966,737.00	94.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,716,800.00	309,816,273.69	40,900,526.31	88.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,139,000.00	17,768,716.00	7,370,284.00	70.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	184,698,600.00	179,875,317.00	4,823,283.00	97.4
<b>Нормативт зардал</b>	<b>1,391,443,000.00</b>	<b>1,229,194,844.00</b>	<b>162,248,156.00</b>	88.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,274,537,900.00	1,117,529,288.00	157,008,612.00	87.7
Хоол, хүнс	86,997,600.00	84,465,556.00	2,532,044.00	97.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,907,500.00	27,200,000.00	2,707,500.00	90.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,236,642,500.00</b>	<b>2,020,168,532.76</b>	<b>216,473,967.24</b>	90.3
Багаж, техник, хэрэгсэл	672,355,900.00	638,718,556.00	33,637,344.00	95.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,135,254,700.00	978,773,345.00	156,481,355.00	86.2
Урсгал засвар	429,031,900.00	402,676,631.76	26,355,268.24	93.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>641,866,700.00</b>	<b>556,716,741.00</b>	<b>85,149,959.00</b>	86.7
Дотоод албан томилолт	641,866,700.00	556,716,741.00	85,149,959.00	86.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,718,713,100.00</b>	<b>1,438,164,797.25</b>	<b>280,548,302.75</b>	83.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,045,875,400.00	858,067,109.75	187,808,290.25	82.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	45,609,300.00	33,442,840.00	12,166,460.00	73.3
Даатгалын үйлчилгээ	46,565,000.00	44,438,332.00	2,126,668.00	95.4
Тээврийн хэрэгслийн татвар	16,068,100.00	10,858,250.50	5,209,849.50	67.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,082,000.00	2,510,625.00	571,375.00	81.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	409,723,600.00	382,701,103.00	27,022,497.00	93.4
Газрын төлбөр	12,232,000.00	7,521,697.00	4,710,303.00	61.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	139,557,700.00	98,624,840.00	40,932,860.00	70.7
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>99,308,100.00</b>	<b>89,602,093.00</b>	<b>9,706,007.00</b>	90.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99,308,100.00	89,602,093.00	9,706,007.00	90.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,558,629,900.00</b>	<b>1,464,058,781.60</b>	<b>94,571,118.40</b>	93.9
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,558,629,900.00</b>	<b>1,464,058,781.60</b>	<b>94,571,118.40</b>	93.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,388,737,400.00	1,305,442,148.00	83,295,252.00	94.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	169,892,500.00	158,616,633.60	11,275,866.40	93.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,388,000,000.00</b>	<b>1,388,000,000.00</b>	<b>0.00</b>	100.0
Барилга байгууламж	1,388,000,000.00	1,388,000,000.00	0.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>44,435,180,500.00</b>	<b>42,381,636,624.35</b>	<b>2,053,543,875.65</b>	95.4

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>44,122,225,500.00</b>	<b>42,069,055,990.35</b>	<b>2,053,169,509.65</b>	95.3
Улсын төсвөөс санхүүжих	44,122,225,500.00	42,069,055,990.35	2,053,169,509.65	95.3
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>312,955,000.00</b>	<b>312,580,634.00</b>	<b>374,366.00</b>	99.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	312,955,000.00	312,580,634.00	374,366.00	99.9
Төсвийн тохируулгын дүн		133,894,407.00	-133,894,407.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	210,713,814.00	-210,713,814.00	0.0
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>4,427</b>	<b>4,385</b>	<b>42</b>	99.1
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>27</b>	<b>27</b>	<b>0</b>	100.0
Төсвийн байгууллага	27	27	0	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>2,200</b>	<b>2,179</b>	<b>21</b>	99.0
Удирдах ажилтан	34	34	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,690	1,669	21	98.8
Үйлчлэх ажилтан	476	476	0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>2,946,108,477.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>2,857,214,677.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>2,374,276,368.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>333,089,521.01</b>
210101	Үндсэн цалин		326,315,761.01
210102	Нэмэгдэл		3,780,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		2,615,760.00
210104	Урамшуулал		378,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>42,221,211.53</b>
210201	Тэтгэврийн даатгал		42,221,211.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>5,956,851.36</b>
210301	Гэрэл, цахилгаан		5,956,851.36
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>115,458,862.00</b>
210401	Бичиг хэрэг		6,985,300.00
210402	Тээвэр, шатахуун		62,491,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		42,982,362.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		<b>32,050,658.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		13,368,650.00
210502	Хоол, хүнс		8,018,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		10,664,008.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>506,632,173.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		436,136,879.00
210602	Тавилга		14,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		24,335,530.00
210604	Урсгал засвар		31,559,764.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>66,593,624.00</b>
210702	Дотоод албан томилолт		66,593,624.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>76,760,120.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		76,760,120.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>1,195,513,348.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,062,386,248.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		133,127,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>482,938,308.10</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>183,866,256.10</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		183,866,256.10
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>44,200,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		44,200,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>254,872,052.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		52,311,936.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		202,560,116.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>88,893,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>88,893,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		88,893,800.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>2,946,108,477.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>2,946,108,477.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		10,786,420.00
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,179,516,720.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		755,805,337.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Ц.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/449 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрхэм зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийг сахиулан, нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчинг дэмжиж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын тогтолцоог шинэчлэн, зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн зохион байгуулах;
- Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зөвлөн туслах үйлчилгээ, сургалт, тандалт судалгаа, хяналт шинжилгээний арга хэлбэртэй хослуулах, эрсдэлийн судалгаа, баазыг өргөжүүлэх замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх;
- Ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх;
- Мэргэжлийн хяналтын байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг сайжруулж, хяналтын үндсэн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг оновчтой болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;
- Шадар сайдын 2021 оны “Үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 94 дүгээр тушаал;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны “Чиг үүрэг, орон тоог шинэчлэн батлах тухай” 82 дугаар тушаал болно.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны А/171 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2021 онд 3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 71.5 хувийн биелэлттэй байна. Мэргэжлийн хяналтын байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаанаас гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод хяналт шалгалт, аудитын хүрээнд 4 байгууллагад хяналт, шалгалт хийхээр төлөвлөснөөс цар тахлын улмаас 3 байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийгээгүй байна. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, аудит хийж, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 9, бусад чиглэлээр 15 нийт 24 зөрчил илрүүлж, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, танилцуулгыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 49,457.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 989.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга**

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 719.1 сая төгрөгөөр буюу 10.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 210.7 сая төгрөг болж, өмнөх оноос 133.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	344,370.3	210,713.8	-133,656.5
<b>Дүн</b>	<b>344,370.3</b>	<b>210,713.8</b>	<b>-133,656.5</b>

Эх сурвалж: МХЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 209.7 сая төгрөг Төрийн сангийн харилцах дансанд, 1.0 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан, төлбөрийн цахим баримтгүйгээр бараа, ажил үйлчилгээ худалдан авсан; /Тухайлбал, МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори 1,076.6 сая, Сэлэнгэ аймгийн МХГ 21.9 сая, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь ХМХА 56.3 сая, Нийслэлийн МХГ 9.1 сая/
- Говь-Алтай аймгийн МХГ баталсан орон тооноос 4 албан хаагчийг илүү ажиллуулж, цалингийн зардалд 37.5 сая төгрөгийг олгосон;
- Дорноговь аймгийн Замын-Үүд боомт дахь ХМХА жижиг мөнгөн сангаас 15.7 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, төлбөр хураамж төлсөн, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, 10.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Нийслэлийн МХГ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас телевиз, цахим хуудсаар мэдээлэл сурталчлуулахаар ААН-тэй гэрээ байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй ААН болон ажилладаггүй 5 цахим сайтад 10.0 сая төгрөгийг шилжүүлсэн зэрэг.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 167.4 сая төгрөг болж, өмнөх оноос 95.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлага дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	5,212.5	1,077.2	4,135.3
Татаас, санхүүжилтийн авлага	10,698.5	40,252.8	-29,554.3
Байгууллагаас авах авлага	53,724.4	123,660.6	-69,936.1
Хувь хүмүүсээс авах авлага	2,371.7	2,372.3	-0.6
<b>Дүн</b>	<b>72,007.1</b>	<b>167,362.9</b>	<b>-95,355.7</b>

Эх сурвалж: МХЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өссөн нь оны эцэст хөрөнгө худалдан авах, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулахаар 145.7 сая төгрөгийн гэрээ байгуулж, авлагаар бүртгэснээс шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай, он дамжсан 20.7 сая төгрөгийн хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- МХЕГ нь 260.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, олон жилийн насжилттай, он дамжсан авлагуудыг шийдвэрлээгүй байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 5,478.3 сая төгрөг болж, өмнөх оноос 816.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Бараа материал дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,002,872.3	864,259.9	-138,612.4
Тусгай зориулалтын материал	127,330.0	118,872.0	-8,458.0
Эм боох	875,542.3	745,387.9	-130,154.4
Бэлэн бүтээгдэхүүн	156,531.2	51,474.8	-105,056.4
Бичиг хэргийн материал	5,134,476.4	4,561,417.5	-573,058.9
Аж ахуйн материал	232,144.5	225,020.7	-7,123.8
Сэлбэг хэрэгсэл	1,537,144.8	1,567,675.2	30,530.4
Түлш, шатах тослох материал	814,824.0	759,221.4	-55,602.6
Барилгын засварын материал	133,891.5	124,902.3	-8,989.3
Хүнсний материал	5,719.2	4,555.2	-1,164.0
Бусад хангамжийн материал	704.9	1,705.8	1,000.9
Мал амьтад	2,410,047.4	1,878,336.8	-531,710.6
<b>Дүн</b>	<b>6,295,011.3</b>	<b>5,478,283.5</b>	<b>-816,727.8</b>

Эх сурвалж: МХЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл буурсан нь Ковид-19 халдварын тохиолдолд зориулан хувийн хамгаалах хэрэгслийн зарцуулалт ихэссэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- МХЕГ нь Хилийн боомт дахь мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд худалдан авсан 67.0 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох нэгжүүдэд шилжүүлээгүй;
- Шатахуун зарцуулалтын тооцоог хийхдээ шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй, шатахуун зарцуулалтын анхан шатны баримт бүрдэл дутуу; /Тухайлбал, Сэлэнгэ аймгийн МХГ нь 3.1 сая, Завхан аймгийн МХГ 1.5 сая, Орхон аймгийн МХГ 0.9 сая/ зэрэг.

3.5.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,573.0 сая төгрөг болж өссөн байна.

Хүснэгт 4. Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	-	1,573,000.0	1,573,000.0
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>1,573,000.0</b>	<b>1,573,000.0</b>

Эх сурвалж: МХЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө данс үлдэгдэлтэй гарсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 1,388.0 сая төгрөгийн барилга, тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагад шилжүүлээгүй, Дорноговь аймгийн Замын-Үүд боомт дахь ХМХА түрээслээд өмчлөх байрыг бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 41,457.8 сая төгрөг болж, өмнөх оноос 3,773.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>35,785,783.7</b>	<b>39,411,606.6</b>	<b>3,625,822.9</b>
Барилга, байгууламж, орон сууц	26,307,475.1	25,791,310.6	-516,164.6
Авто-тээврийн хэрэгсэл	1,821,225.3	1,918,636.5	97,411.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,771,323.7	9,073,927.3	4,302,603.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	953,293.6	662,372.4	-290,921.2
Зам, гүүрний байгууламж	3,982.9	6,533.3	2,550.5
Бусад үндсэн хөрөнгө	1,876,483.2	1,906,826.4	30,343.2
Дуусаагүй барилга, байгууламж	52,000.0	52,000.0	0.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,898,713.1</b>	<b>2,046,180.2</b>	<b>147,467.1</b>

Программ хангамж	286,744.2	450,798.6	164,054.4
Бусад биет бус хөрөнгө	1,611,968.9	1,595,381.6	-16,587.3
<b>Дүн</b>	<b>37,684,496.8</b>	<b>41,457,786.8</b>	<b>3,773,290.0</b>

Эх сурвалж: МХЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 1,545.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, Буянт-Ухаа боомт дахь ХМХА АНУ-ын Эрчим хүчний яамнаас 5,265.4 сая төгрөгийн цацрагийн тоног төхөөрөмж, бусад байгууллагууд 356.5 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, 334.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн, 176.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж, бусад 853.7 сая төгрөг нийт 8,531.4 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд 43.8 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж, 81.8 сая төгрөгийг балансаас баланст шилжүүлэн, 802.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган, бусад 57.6 сая төгрөг нийт 986.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 4,668.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг байгуулжээ.

**Аудитын илрүүлэлт:**

- МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй эвдэрч гэмтсэн үйл ажиллагааны болон хоцрогдлын элэгдэлд орсон 133 нэрийн 1,524.2 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй;
- Төв аймгийн МХГ-ын даргын 2021 оны А/26 дугаар тушаалаар 4 нэр төрлийн 8 ширхэг 10.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахдаа үнийн харьцуулалт хийсэн мэдээлэл, материал байхгүй;
- Төв аймгийн МХГ нь аймгийн ИТХ-ын 2021 оны 62 дугаар тогтоолоор 14 нэр төрлийн 15 ширхэг 8.8 сая төгрөгийн хөрөнгийг актлах данснаас хасахаар шийдвэрлэснийг хэрэгжүүлээгүй;
- Баянхонгор аймгийн МХГ нь эд хогшлын зардлаас цахим хурлын тоног, төхөөрөмж авахаар 4.5 сая төгрөгийг шилжүүлж, хөрөнгө ирээгүй байхад хөрөнгийг орлогод авсан;
- Хөвсгөл аймгийн МХГ зардлын зориулалт зөрчин урсгал засварын зардлаас 1.4 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 0.4 сая төгрөгийн нийт 1.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зэрэг.

**3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 296.2 сая төгрөг болж, өмнөх оноос 97.6 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 6. Нийт өр төлбөр дансны үлдэгдэл**

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	4,874.9	6,593.3	1,718.3
Байгууллагад төлөх өглөг	291,312.7	191,846.6	-99,466.1
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	177.5	177.5
<b>Дүн</b>	<b>296,187.6</b>	<b>198,617.4</b>	<b>-97,570.3</b>

Эх сурвалж: МХЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 122.3 сая төгрөгийн барилгын барьцаа, байгууллага, хувь хүнд өгөх 76.3 сая төгрөгийн өглөг байна.

Тайлант онд 198.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Тайлант онд өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, өглөг үүсгэсэн, өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг. /Тухайлбал, МХЕГ 231.7 сая, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь ХМХА 0.2 сая төгрөг/

**3.5.7 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 48,689.7 сая төгрөг болж, өмнөх оноос 4,589.9 сая төгрөгөөр өссөн байна.



Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	16,447,971.3	16,447,971.3	0.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>24,793,074.1</b>	<b>29,233,605.1</b>	<b>4,440,531.0</b>
Өмнөх үеийн үр дүн	18,704,518.4	24,839,693.4	6,135,174.9
Тайлант үеийн үр дүн	6,088,555.7	4,393,911.7	-1,694,643.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,858,717.6	3,008,098.3	149,380.7
<b>Дүн</b>	<b>44,099,762.9</b>	<b>48,689,674.6</b>	<b>4,589,911.7</b>

Эх сурвалж: МХЕГ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 4,440.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд түрээслээд өмчлөх конторын зориулалттай барилгад өмнөх онд төлсөн 46.0 сая төгрөгийн төлбөр, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 0.4 сая, дахин үнэлгээ хийсэн хөрөнгийг акталсны 0.2 сая төгрөгийг бүртгэж, тайлагнасан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь 2021 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 59,233.4 сая, хөрөнгийн зардлыг 39,756.7 сая, нийт 98,990.1 сая төгрөгийг төлөвлөж, санхүүжүүлэх эх үүсвэр 98,677.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 313.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт зардлыг 54,554.9 сая төгрөгөөр бууруулан 44,435.2 сая төгрөгөөр баталжээ. Үүнд: цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шийтгэлийн зардлыг 11,771.3 сая, хөрөнгийн зардлыг 38,368.7 сая, бусад зардлыг 4,414.9 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээнд зориулан 43,047.2 сая төгрөгийн урсгал зардал, 1,388.0 сая төгрөгийн хөрөнгийн зардал, нийт 44,435.2 сая төгрөгийн төсвийг баталжээ. Зардлын 44,122.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 313.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 44,122.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 312.6 сая төгрөгийн орлогыг олж, нийт 44,435.2 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Үүнээс 40,993.4 сая төгрөгийг урсгал зардалд, 1,388.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, үлдэгдэл 2,053.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 42,381.4 сая төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийг 885.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 280.5 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 216.5 сая, нормативт зардлыг 162.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70417	Мэргэжлийн хяналт	44,435,180.5	42,381,398.7	2,053,781.8	95.4
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	41,024,566.8	39,125,688.4	1,898,878.4	95.4
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	76,407.7	71,942.9	4,464.8	94.2
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	301,734.5	264,939.0	36,795.5	87.8
1.4	80227	Лабораторийн итгэмжлэл	85,841.6	66,769.6	19,072.0	77.8
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,558,629.9	1,464,058.8	94,571.1	93.9
1.6	80918	Бусад	1,388,000.0	1,388,000.0	0.0	100.0

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 3,900.0 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 3,465.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Үйл ажиллагааны орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,900,000.0	3,465,249.7	434,750.3	88.9
<b>Нийт дүн</b>	<b>3,900,000.0</b>	<b>3,465,249.7</b>	<b>434,750.3</b>	<b>88.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 2,179.5 сая, хандив тусламжаар 10.8 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 755.8 сая, нийт 2,946.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 2,602.3 сая, хөрөнгийн зардалд 88.9 сая, нийт 2,691.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 254.9 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралаар Шадар сайдын 2021 онд хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн хүрээнд 19 арга хэмжээний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталсан байна. Үүнээс Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь мэргэжлийн хяналт хөтөлбөрийн хүрээнд доорх 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 88.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанар, тоо хэмжээний үзүүлэлт

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мэргэжлийн хяналт			44,435,180.5	42,381,398.7	2,053,781.8	88.2
1.1	Хяналт шалгалтын үр дүнгээр шалгалтад	60	48.7	741,174.8	646,318.8	94,856.0	87.2

	хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувь						
1.2	Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувиар/	75	76.6	40,824,187.0	38,917,038.3	1,907,148.7	95.3
1.3	Улсын байцаагчдын гаргасан шийдвэрийн биелэлт /акт, нөхөн төлбөр/, /хувиар/	74	66.9	139,557.7	98,624.8	40,932.9	70.7
1.4	Лабораторийн шинжилгээний итгэмжлэгдсэн үзүүлэлтийн өсөлт	1240	1292	2,730,261.0	2,719,416.8	10,844.2	99.6

Тайлант онд хэрэгжүүлсэн 2 арга хэмжээ зорилтот түвшний үзүүлэлтийг хангаж, 2 арга хэмжээ зорилтот түвшний үзүүлэлтэд хүрч ажиллаагүй байна. Үүнд:

- Хууль сахин мөрдөлтийн түвшин болон лабораторийн шинжилгээний итгэмжлэгдсэн үзүүлэлтийн өсөлт 2 арга хэмжээний хүрээнд 43,554.4 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 41,636,5 сая төгрөгийг зарцуулж, 1,918.0 сая төгрөгийг хэмнэж, зорилтот түвшний үзүүлэлтэд хүрч, ажилласан байна.
- Хяналт шалгалтын үр дүнгээр шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 60 хувьд хүргэх, улсын байцаагчдын гаргасан шийдвэрийн биелэлтийг 74.0 хувьд хүргэх 2 зорилт тавин 880.7 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 744.9 сая төгрөгийг зарцуулж, 138.8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдэж, зорилтот түвшний үзүүлэлтийг хангаагүй, дунджаар 85.8 хувийн биелэлттэй ажилласан байна.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны “Үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 94 дүгээр тушаалаар бүтэц, орон тоог шинэчлэн баталжээ. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдлагын орон тоог дарга 1, тэргүүн дэд дарга 1, дэд дарга 2, нийт орон тооны дээд хязгаарыг 149 байсныг 187 байхаар тогтоож өөрчилжээ. Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори ажиллуулахаар заасан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгаанд анхаарал татсан асуудал гараагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитаар хөндөх гол асуудал гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь шилэн дансны цахим хуудсанд нийт 18,832.1 сая төгрөгийн 3488 мэдээлэл байршуулахаас 861.4 сая төгрөгийн 307 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1,413.9 сая төгрөгийн 137 мэдээллийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх, зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 5.2 сая төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгснийг үнэлэхэд албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 50.0 хувьтай байна.

*Хүснэгт 11. Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	5.2	1	-	1	5.2	50.0
Зөвлөмж	2	-	1	-	1	-	50.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>5.2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>5.2</b>	<b>50.0</b>

Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд төсвөөс 5.2 сая төгрөг олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлэх 1 албан шаардлага, дотоод аудитын үйл ажиллагаа хэрэгжүүлэх 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Иймд хэрэгжээгүй албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан гүйцээн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,861.1 сая төгрөгийн 98 алдаа, зөрчил илрүүлснээс, 4,065.4 сая төгрөгийн 34 алдааг залруулж, 3.5 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 1,569.2 сая төгрөгийн зөрчилд 20 албан шаардлага хүргүүлж, 223.0 сая төгрөгийн 39 алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 1,795.7 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 989.1 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

##### 4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 27 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 26 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 25, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 2,130.5 сая төгрөгийн 92 алдаа, зөрчил илрүүлснээс, 583.6 сая төгрөгийн 30 алдааг залруулж, 3.5 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 1,320.4 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага хүргүүлж, 223.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 39 зөвлөмжийг өгсөн.

##### 4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

###### 4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 3,481.8 сая төгрөгийн 4 алдааг залруулав. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 1,388.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүйг бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үйл ажиллагааны орлого 9,043.0 сая, үйл ажиллагааны зардал 8,917.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, тайлант онд 1,387.4 сая төгрөгийн устгал бичилт дутуу хийсэн;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт 0.6 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн өсөлт 45.6 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зардал 2,350.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, тайлант онд 660.1 сая төгрөгийн устгал бичилт дутуу хийснийг тус тус залруулав.

###### 4.2.2 Албан шаардлага

1. Тайлант онд 50.7 сая төгрөгийн авлага, 198.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Харьяа 27 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 1,546.9 сая төгрөгийн 62 алдаа, зөрчил илрүүлснээс, 3.5 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 1,320.4 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага хүргүүлж, 223.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 39 зөвлөмжийг өгсөн байна. Дотоод хяналт үр нөлөөгүй, сул байгаагаас залруулагдаагүй алдаа зөрчил өмнөх оноос 5.6 дахин өссөн, өмнөх оны аудитаар өгсөн 5.9 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 1.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### 5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>																				
1	МХЕГ	АХГ-2022/11/НА-СТА-ТТЗ	1		1				6	3,730,618.8	4	3,481,794.9			2	248,823.9				
	Дүн		1		1				6	3,730,618.8	4	3,481,794.9			2	248,823.9				
<b>Төсвийн шууд захирагч</b>																				
1	МХЕГ-ын аппарат	АХГ-2022/154/НА-СТА-ТШЗ	1					1	8	194,650.0					3	123,246.6			5	71,403.4
2	МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа, лаборатори	АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ	1		1				3	1,238,306.4	1	161,705.8			1	1,076,600.6			1	-
3	ХМХА-Сэлэнгэ Сүхбаатар боомт	СЭА-2022/255/НА-СТА-ТШЗ	1	1					10	83,193.2	7	26,406.3							3	56,786.9
4	ХМХА-Буянт-Ухаа боомт	АХГ-2022/156/НА-СТА-ТШЗ	1	1					-	-										
5	ХМХА-Дорноговь Замын-Үүд боомт	ДГА-2022/126/НА-СТА-ТШЗ	1	1					7	34,221.0	2	2,021.0			4	32,200.0			1	-
6	Нийслэлийн мэргэжлийн хяналтын алба	НТАГ-2022/789/НА-СА-ТШЗ	1	1					5	211,920.6	1	183,866.3	1	3,000.0	2	15,914.3			1	9,140.0

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Архангай аймгийн МХГ	АРА-2022/16/ НА-СТА-ТШЗ	1	1				1	23,792.0	1	23,792.0							
8	Баян-Өлгий аймгийн МХГ	БӨА-//НА- СТА-ТШЗ	1	1				-	-									
9	Баянхонгор аймгийн МХГ	БНА- 2022/101/НА- СТА-ТШЗ	1	1				2	4,500.0							2	4,500.0	
10	Булган аймгийн МХГ	БУА- 2022/124/НА- СТА-ТШЗ	1	1				4	1,080.6	2	993.1	1	87.5			1	-	
11	Говь-Алтай аймгийн МХГ	ГСА- 2022/15/СТА- ТШЗ	1	1				7	81,081.1	2	12,500.0	1	232.2	3	68,348.9	1	-	
12	Говьсүмбэр аймгийн МХГ	ДАА- 2022/124/НА- СА-ТШЗ	1	1				3	12,238.9	1	2,987.1					2	9,251.8	
13	Дархан-Уул аймгийн МХГ	ДГА- 2022/124/124/ НА-СТА-ТШЗ	1	1				1	1,088.6							1	1,088.6	
14	Дорноговь аймгийн МХГ	ДОА- 2022/165/НА/ СТА-ТШЗ	1	1				6	1,900.0	2	1,900.0					4	-	
15	Дорнод аймгийн МХГ	ДУА- 2022/20/НА- СТА-ТШЗ	1	1				-	-									
16	Дундговь аймгийн МХГ	ЗАА- 2022/200/СТА -ТШЗ	1	1				1	900.0					1	900.0			
17	Завхан аймгийн МХГ	ОРА- 2022/33/НА- СТА-ТШЗ	1	1				6	114,117.5	3	109,965.5					3	4,152.0	
18	Орхон аймгийн МХГ	ӨВА- 2022/96/НА- СТА-ТШЗ	1	1				6	19,690.3	1	32.0	2	196.0	1	845.5	2	18,616.8	
19	Өвөрхангай аймгийн МХГ	ӨМА- 2022/114/НА- СТА-ТШЗ	1	1				1	200.0	1	200.0							
20	Өмнөговь аймгийн МХГ	СБА- 2022/12/НА- СТА-ТШЗ	1	1				1	-					1				
21	Сүхбаатар аймгийн МХГ	СЭА- 2022/254-НА- СТА-ТШЗ	1	1				3	2,000.0							3	2,000.0	
22	Сэлэнгэ аймгийн МХГ	ТӨА- 2022/15/НА- СТА-ТШЗ	1	1				3	24,956.8							3	24,956.8	
23	Төв аймгийн МХГ	УВА- 2022/82/НА- СТА-ТШЗ	1	1				4	47,836.4	1	27,831.7			1	713.0	2	19,291.7	



**Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

24	Увс аймгийн МХГ	ХОА-2022/23/НА-СТА-ТШЗ	1	1			1	1,080.0	1	1,080.0									
25	Ховд аймгийн МХГ	ХӨА-2022/240/НА-СТА-ТШЗ	1	1			3	2,549.0	1	2,549.0						2		-	
26	Хөвсгөл аймгийн МХГ	ХЭА-2022/12/НА-СТА-ТШЗ	1	1			3	7,500.0	1	5,700.0						2		1,800.0	
27	Хэнтий аймгийн МХГ	ХЭА-2022/12/НА-СТА-ТШЗ	1	1			3	21,700.0	2	20,100.0			1	1,600.0					
	Дүн		27	25	1		1	92	2,130,502.4	30	583,629.8	5	3,515.7	18	1,320,368.9	-	-	39	222,988.0
	<b>Нийт дүн</b>		<b>28</b>	<b>25</b>	<b>2</b>		<b>1</b>	<b>98</b>	<b>5,861,121.2</b>	<b>34</b>	<b>4,065,424.7</b>	<b>5</b>	<b>3,515.7</b>	<b>20</b>	<b>1,569,192.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>39</b>	<b>222,988.0</b>

**5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>														
1	МХЕГ	АХГ-2022/11/НА-СТА-ТТЗ	1	-					1	-				
	Дүн		1	-					1	-				
<b>Төсвийн шууд захирагч</b>														
1	МХЕГ-ын аппарат	АХГ-2022/154/НА-СТА-ТШЗ	1	-					1	-				
2	МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа, лаборатори	АХГ-2022/155/НА-СТА-ТШЗ	2	607,264.6					2	607,264.6				
3	ХМХА-Сэлэнгэ Сүхбаатар боомт	СЭА-2022/255/НА-СТА-ТШЗ	-	-										
4	ХМХА-Буюнт-Ухаа боомт	АХГ-2022/156/НА-СТА-ТШЗ	-	-										
5	ХМХА-Дорноговь Замын-Үүд боомт	ДГА-2022/126/НА-СТА-ТШЗ	-	-										
6	Нийслэлийн мэргэжлийн хяналтын алба	НТАГ-2022/789/НА-СА-ТШЗ	1	56,988.6									1	56,988.6
7	Архангай аймгийн МХГ	АРА-2022/16/НА-СТА-ТШЗ	1	3,574.8					1	3,574.8				
8	Баян-Өлгий аймгийн МХГ	БӨА-//НА-СТА-ТШЗ	-	-										
9	Баянхонгор аймгийн МХГ	БНА-2022/101/НА-СТА-ТШЗ	1	-									1	-
10	Булган аймгийн МХГ	БУА-2022/124/НА-СТА-ТШЗ	-	-										
11	Говь-Алтай аймгийн МХГ	ГСА-2022/15/СТА-ТШЗ	-	-										
12	Говьсүмбэр аймгийн МХГ	ДАА-2022/124/НА-СА-ТШЗ	1	-									1	-
13	Дархан-Уул аймгийн МХГ	ДГА-2022/124/124/НА-СТА-ТШЗ	-	-										
14	Дорноговь аймгийн МХГ	ДОА-2022/165/НА/СТА-ТШЗ	-	-										
15	Дорнод аймгийн МХГ	ДУА-2022/20/НА-СТА-ТШЗ	-	-										

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

16	Дундговь аймгийн МХГ	ЗАА-2022/200/СТА-ТШЗ	3	1,631.8	2	1,158.3		1	473.5				
17	Завхан аймгийн МХГ	ОРА-2022/33/НА-СТА-ТШЗ	-	-									
18	Орхон аймгийн МХГ	ӨВА-2022/96/НА-СТА-ТШЗ	-	-									
19	Өвөрхангай аймгийн МХГ	ӨМА-2022/114/НА-СТА-ТШЗ	-	-									
20	Өмнөговь аймгийн МХГ	СБА-2022/12/НА-СТА-ТШЗ	1	38,129.5							1	38,129.5	
21	Сүхбаатар аймгийн МХГ	СЭА-2022/254/НА-СТА-ТШЗ	-	-									
22	Сэлэнгэ аймгийн МХГ	ТӨА-2022/15/НА-СТА-ТШЗ	1	-				1	-				
23	Төв аймгийн МХГ	УВА-2022/82/НА-СТА-ТШЗ	-	-									
24	Увс аймгийн МХГ	ХОА-2022/23/НА-СТА-ТШЗ	-	-									
25	Ховд аймгийн МХГ	ХӨА-2022/240/НА-СТА-ТШЗ	-	-									
26	Хөвсгөл аймгийн МХГ	ХЭА-2022/12/НА-СТА-ТШЗ	1	-							1	-	
27	Хэнтий аймгийн МХГ	ХЭА-2022/12/НА-СТА-ТШЗ	-	-									
	Дүн		<b>13</b>	<b>707,589.3</b>	<b>2</b>	<b>1,158.3</b>	-	<b>6</b>	<b>611,312.9</b>	-	-	<b>5</b>	<b>95,118.1</b>
	Нийт дүн		<b>14</b>	<b>707,589.3</b>	<b>2</b>	<b>1,158.3</b>	-	<b>7</b>	<b>611,312.9</b>	-	-	<b>5</b>	<b>95,118.1</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 412/А0170080

Улаанбаатар хот

АХГ-2022/06/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 50,746,550.85 төгрөгийн авлага, 198,077,309.86 төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, ерөнхий нягтлан бодогч Н.Найданболд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 413/А0140080

Улаанбаатар хот

АХГ-2022/06/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа 27 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,838,091,700.00 төгрөгийн 105 алдаа, зөрчил илэрснээс 584,788,100.00 төгрөгийн 32 алдааг залруулж, 3,515,700.00 төгрөгийн 5 төлбөрийн акт, 1,931,681,800.00 төгрөгийн 25 албан шаардлага, 318,106,100.00 төгрөгийн 43 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод хяналт үр нөлөөгүй, сул байгаагаас залруулагдаагүй алдаа зөрчил өмнөх оноос 8.1 дахин өссөн, өмнөх оны аудитаар өгсөн 5,908,100.00 төгрөгийн 5 төлбөрийн акт, 1,300,000.00 төгрөгийн 2 албан шаардлага, 6 зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар өгсөн Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын даргын тушаалаар ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд төсвөөс 5,200,000.00 төгрөгийг олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлэх 1 албан шаардлага, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 1 зөвлөмж;
- Харьяа байгууллагуудын 5,908,100.00 төгрөгийн 5 төлбөрийн акт, 1,300,000.00 төгрөгийн 1 албан шаардлага, 5 зөвлөмж хэрэгжээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1 "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, ерөнхий нягтлан бодогч Н.Найданболд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 414/А0140080  
АХГ-2022/06/НВ-СТА-ТТЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд харьяа 27 байгууллагын 18,832,124,500.00 төгрөгийн 3488 мэдээлэл байршуулахаас 861,439,300.00 төгрөгийн 307 мэдээллийг хугацаа хоцроож, 1,413,897,070.00 төгрөгийн 137 мэдээллийг мэдээлээгүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлэх, хэрэгжилтэд хяналт тавих, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, ерөнхий нягтлан бодогч Н.Найданболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-371.Docx

701081850